

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/150/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага.....	19
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/27
танай -ны № -г

**ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Э.ПҮРЭВСҮРЭН ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны эцэст 39,709.9 мянган төгрөгийн бараа материалыг биечлэн тоолоогүй, тооллогын үр дүнг хэлэлцэж, баталгаажуулаагүй, 1,295.4 мянган төгрөгийн НДШ-ийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 1,175.0 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-т "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/, 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

19020400

D 2022/2022 он/ALBAN BICHIG

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31,141,313.36</u>	<u>41,005,406.51</u>
33	АВЛАГА	7,996.36	1,295,449.51
335	Бусад авлага	7,996.36	1,295,449.51
3351	Байгууллагаас авах авлага	7,996.36	1,295,449.51
35	БАРАА МАТЕРИАЛ	31,133,317.00	39,709,957.00
351	Түүхий эд материал	2,424,500.00	2,424,500.00
35110	Тусгай зориулалттай материал	2,190,500.00	2,190,500.00
35130	Эм боох материал	234,000.00	234,000.00
354	Хангамжийн материал	28,708,817.00	37,285,457.00
35410	Бичиг хэргийн материал	442,500.00	1,497,500.00
35420	Аж ахуйн материал	22,863,800.00	27,835,850.00
35460	Хүнсний материал	5,402,517.00	7,952,107.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>375,909,443.28</u>	<u>527,351,355.90</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	375,909,443.28	527,351,355.90
392	Биет хөрөнгө	371,901,443.28	523,343,355.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	374,628,000.32	538,945,763.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	21,447,828.24	32,925,590.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,874,000.00	27,350,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	16,137,116.99	15,879,412.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,816,313.69	12,986,313.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	7,758,465.30	7,994,313.98
39209	Зам, гүүрийн байгууламж	659,436.80	659,436.80
39210	Хуримтлагдсан элэгдэл		65,943.66
39217	Ном	267,103.00	267,103.00
393	Биет бус хөрөнгө	4,008,000.00	4,008,000.00
39301	Программ хангамж	157,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	157,000.00	100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,008,000.00	4,008,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>407,050,756.64</u>	<u>568,356,762.41</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>407,050,756.64</u>	<u>568,356,762.41</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	407,050,756.64	568,356,762.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	91,127,106.80	91,127,106.80
51101	Өмч: - төрийн	91,127,106.80	91,127,106.80
512	Хуримтлагдсан үр дүн	(83,141,193.59)	78,164,812.18
51210	Өмнөх үеийн үр дүн	(83,141,193.59)	(83,141,193.59)
51220	Тайлант үеийн үр дүн		161,306,005.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	399,064,843.43	399,064,843.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>407,050,756.64</u>	<u>568,356,762.41</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	292,106,200.00	446,613,063.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,499,000.00	441,556,863.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,499,000.00	164,317,763.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,499,000.00	164,317,763.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,499,000.00	164,317,763.00
122	Тусламжийн орлого	2,000,000.00	3,860,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	2,000,000.00	3,860,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	273,379,100.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого		239,191,700.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		34,187,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	286,607,200.00	5,056,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	32,297,000.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	32,297,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,443,900.00	5,056,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,443,900.00	5,056,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	242,866,300.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	242,866,300.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	301,365,672.02	284,691,744.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,365,672.02	284,691,744.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,160,701.44	252,550,546.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,991,606.79	167,438,230.00
210101	Үндсэн цалин	108,456,597.79	119,472,019.50
210102	Нэмэгдэл	26,769,304.00	35,870,028.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,934,084.00	4,656,000.00
210104	Урамшуулал	14,831,621.00	7,440,182.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,192,646.42	23,815,646.86
210201	Тэтгэврийн даатгал	16,269,097.13	16,377,746.86
210202	Тэтгэмжийн даатгал	1,756,793.77	1,859,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,404,953.20	1,487,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	365,027.99	371,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,396,774.33	3,718,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,581,629.00	32,397,355.00
210301	Гэрэл, цахилгаан	2,052,309.00	2,160,267.00
210302	Түлш, халаалт	28,347,320.00	30,237,088.00
210303	Цэвэр, бохир ус	182,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	1,537,800.00	1,218,000.00
210401	Бичиг хэрэг	170,800.00	259,000.00
210402	Тээвэр, шатахуун	160,000.00	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	56,000.00	20,000.00
210404	Ном, хэвлэл	25,000.00	50,000.00

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,126,000.00	289,000.00
2105	Нормативт зардал	11,151,910.00	11,276,327.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,820.00	45,000.00
210502	Хоол, хүнс	10,674,890.00	10,765,827.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	464,200.00	465,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	-
210702	Дотоод албан томилолт	80,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	495,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	495,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,630,109.23	15,904,988.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,254,400.00	872,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	520,000.00	222,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,855,709.23	14,810,538.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,204,970.58	32,141,198.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,443,900.00	5,056,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,443,900.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		5,056,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,215,371.00	-
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	1,215,371.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,545,699.58	27,084,998.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,545,699.58	27,084,998.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(9,259,472.02)</u>	<u>161,921,318.04</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	615,312.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		615,312.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(615,312.28)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(9,259,472.02)</u>	<u>161,306,005.76</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	-73,881,721.57	416,310,228.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	-73,881,721.57	416,310,228.66
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-9,259,472.02	-9,259,472.02
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	-83,141,193.59	407,050,756.64
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	-92,400,665.61	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	-83,141,193.59	407,050,756.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			161,306,005.76	161,306,005.76
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	78,164,812.17	568,356,762.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	286,607,200.00	278,435,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	273,379,100.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	273,379,100.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого		239,191,700.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		34,187,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	286,607,200.00	5,056,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	32,297,000.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	32,297,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,443,900.00	5,056,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,443,900.00	5,056,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	242,866,300.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	242,866,300.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	286,517,200.00	278,435,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	286,517,200.00	278,435,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	223,312,229.42	246,294,102.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	154,995,334.00	167,438,230.00
210101	Үндсэн цалин	109,460,325.00	119,472,019.50
210102	Нэмэгдэл	26,769,304.00	35,870,028.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,934,084.00	4,656,000.00
210104	Урамшуулал	14,831,621.00	7,440,182.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,192,646.42	25,103,100.00
210201	Тэтгэврийн даатгал	16,269,097.13	17,665,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,756,793.77	1,859,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,404,953.21	1,487,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	365,027.98	371,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,396,774.33	3,718,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,581,629.00	33,409,355.00
210301	Гэрэл, цахилгаан	2,052,309.00	3,172,267.00
210302	Түлш, халаалт	28,347,320.00	30,237,088.00
210303	Цэвэр, бохир ус	182,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	1,048,100.00	3,040,000.00
210401	Бичиг хэрэг	80,000.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	160,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	56,000.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	25,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		300,000.00

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	727,100.00	2,190,000.00
2105	Нормативт зардал	9,999,700.00	14,860,417.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,000.00	45,000.00
210502	Хоол, хүнс	9,527,700.00	13,315,417.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	100,000.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	719,820.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	719,820.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,195,000.00	1,843,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,675,000.00	1,159,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	520,000.00	684,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,204,970.58	32,141,198.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,443,900.00	5,056,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,443,900.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		5,056,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,215,371.00	-
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	1,215,371.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,545,699.58	27,084,998.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,545,699.58	27,084,998.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	90,000.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	90,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	90,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	90,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	90,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(90,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	273,379,100.00	246,294,102.00	27,084,998.00	90.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	273,379,100.00	246,294,102.00	27,084,998.00	90.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	273,379,100.00	246,294,102.00	27,084,998.00	90.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	185,949,600.00	167,438,230.00	18,511,370.00	90.04
210101	Үндсэн цалин	119,214,800.00	119,472,019.50	(257,219.50)	100.22
210102	Нэмэгдэл	40,390,800.00	35,870,028.50	4,520,771.50	88.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600,000.00	4,656,000.00	1,944,000.00	70.55
210104	Урамшуулал	19,744,000.00	7,440,182.00	12,303,818.00	37.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,103,100.00	25,103,100.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	17,665,200.00	17,665,200.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,859,500.00	1,859,500.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,487,600.00	1,487,600.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	371,900.00	371,900.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,718,900.00	3,718,900.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,687,400.00	33,409,355.00	278,045.00	99.17
210301	Гэрэл, цахилгаан	3,250,000.00	3,172,267.00	77,733.00	97.61
210302	Түлш, халаалт	30,237,400.00	30,237,088.00	312.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00		200,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,040,000.00	3,040,000.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	200,000.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	50,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.00	2,190,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	23,156,000.00	14,860,417.00	8,295,583.00	64.18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.00	45,000.00	-	100.00
210502	Хоол, хүнс	21,611,000.00	13,315,417.00	8,295,583.00	61.61
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны	100,000.00	100,000.00	-	100.00

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	зардал				
210702	Дотоод албан томилолт	100,000.00	100,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,843,000.00	1,843,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,159,000.00	1,159,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	684,000.00	684,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	273,379,100.00	273,379,100.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	239,191,700.00	239,191,700.00	-	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	239,191,700.00	239,191,700.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,187,400.00	34,187,400.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	34,187,400.00	34,187,400.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	15.00	15.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,056,200.00	5,056,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,056,200.00	5,056,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,056,200.00	5,056,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,056,200.00	5,056,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,056,200.00	5,056,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,056,200.00	5,056,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,056,200.00	5,056,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,056,200.00	5,056,200.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх, авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахыг эрхэм зорилгоо болгон анхан шатны боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/03 дугаар тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 онд дотоод хяналтын 17 үйл ажиллагааны гүйцэтгэхээр төлөвлөгөө батлуулан, дотоод хяналтын ажлаа улирал бүр тайлагнан ажилласан.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 273,379.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 4,100.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,075.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 273,379.1 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 5,056.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 278,435.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 164,317.8 мянган төгрөгийн барилга байгууламж, 1,230.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,320.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 166,867.8 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 166,867.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 1,310.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 15,093.9 мянган төгрөгийн, нийт 16,403.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 7,827.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,295.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Энэ нь НДШ-ийн авлага байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулаагүй байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна. Бараа материал 39,709.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 527,351.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	8.0	1,295.4	1,287.4
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	31,133.3	39,709.9	8,576.6
Үндсэн хөрөнгө	375,909.4	527,351.4	151,442.0
Нийт хөрөнгө	407,050.7	568,356.7	161,306.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	407,050.7	568,356.7	161,306.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	407,050.7	568,356.7	161,306.0

Бараа материалын дансны үлдэгдэл 39,709.9 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 8,576.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 527,351.4 мянган төгрөг болж 151,442.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 568,356.7 мянган төгрөг болж 161,306.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 273,379.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 273,379.1 мянган төгрөгөөр урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 239,191.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 34,187.4 мянган төгрөгийн, нийт 273,379.1 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 246,294.1 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 27,085.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 246,294.1 мянган төгрөг буюу 90.1 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 5,056.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал шилжүүлэгт 5,056.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 164,317.8 мянган төгрөгийн барилга байгууламж, 1,230.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,320.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 166,867.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Тайлант хугацаанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглагдах боломжгүй 3,961.0 мянган төгрөгийн хөрөнгийг Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн шийдвэрийн дагуу акталсан.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст 39,709.9 мянган төгрөгийн бараа материалыг биечлэн тоолоогүй, тооллогын үр дүнг хэлэлцэж, баталгаажуулаагүй, 1,295.4 мянган төгрөгийн НДШ-ийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 1,175.0 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-т "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/", 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 6 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалтын дагуу файлаар болон цаасаар бүрэн бүрдүүлж өгөөгүй, санхүүгийн тайлангийн холбогдох журнал, дэлгэрэнгүй бүртгэлийг файлаар ирүүлээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,402.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,154.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Ихмонгол Хөлөг Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад аудитад шаардлагатай санхүүгийн тайлан, бусад холбогдох материалаа хуулийн хугацаа хоцроосноос цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл үүсэж, шалгагдагч байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар цалинтай холбоотой шийдвэрүүд болон үндсэн хөрөнгө, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг шалгаагүй тул дараагийн аудитаар цалинтай холбоотой ажил гүйлгээ, үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлийг нарийвчилсан горим хэрэгжүүлэн шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 44,497.2 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 180.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 41,846.8 мянган төгрөгийн зөрчил арилгах 5 албан шаардлага хүргүүлж, 2,470.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулга хийгдээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 180.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

1. Тайлант хугацаанд Үндсэн ажлаас гадуур давхар хөдөлмөр эрхэлдэг 1 албан хаагчид ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцсоны улмаас нийт 180.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгаж, гарт олгох цалинг илүү олгосон нь: ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар 41,846.8 мянган төгрөгийн зөрчил арилгах 5 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/10 дугаар "Эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулах ажлын хэсэг томилох" тушаалаар эд хөрөнгө тоолох ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг гүйцэтгэхдээ 39,709,957 төгрөгийн бараа материалыг биечлэн тоолоогүй, тооллогын үр дүнг хэлэлцэж, баталгаажуулаагүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс", 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн хөрөнгө, бараа материалын жилийн эцсийн тооллогын үр дүнг хэлэлцэн баталгаажуулж, тооллогыг бодитой гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд харилцагч 3 байгууллагын 727.7 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримтаар баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6-д "Тооцооны маягтыг нөхөх заавар 5. Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим

баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч ..." гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3. Байгууллагын НББ-ийн үйл ажиллагаанд НББ-ийн бодлогын баримт бичиг ашигладаггүй, НББ-ийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн боловсруулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 6 мэдээллийг хугацаа хоцроосон, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5. Тайлант хугацаанд гэрэл цахилгааны зардлаас 1,012.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материал бэлтгэсэн, цалингийн зардлаас МХГ-д актын төлбөр 397.2 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах" заавартай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Ангилал", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд "Билгүүн түшиг" ХХК-д анхан шатны баримтгүй 1,175.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх

2. *Балансын данстай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тусгагдсан 1,295.4 мянган төгрөгийн НДШ-ийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг	8	44,497.2	-	-	1	180.0	5	41,846.8	2	2,470.4

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn